

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ УДИРДЛАГААР ХАНГАХ, ӨМЧИЙН БОДЛОГО, ШИЙДВЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>							
1	<b>Зорилт 1. Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулна.</b>						
1.1	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын байдалд хяналт тавьж, зөвлөмж өгөх	ОНТ 8.2	Тухайн жилд хамрагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо	142	-	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 15 сум, 139 байгууллагад орон нутгийн өмчийн эд хөрөнгөд хяналт шалгалт зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлээд байна.	30
1.2	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй байгаа хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулан ашиглалтыг сайжруулах	-	Орлого төвлөрүүлэх хувь	95	40	Орон нутгийн өмчит 11 сум, 24 байгууллагын 130 иргэн, хуулийн этгээдтэй “Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ”-г байгуулан орлого төвлөрүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар түрээсийн орлогын дансанд 6.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. Мөн орон нутгийн өмчит 9	100


						байгууллагын 11 тээврийн хэрэгсэл, 4 барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 79.7 төгрөг, Орон сууц хувьчлалын орлогоос 21.1 төгрөг нийт 100.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлээ.	
1.3	Улсын болон орон нутгийн төсөв, гадаад дотоодын зээл, тусламж, хандив болон бусад эх үүсвэрээр бэлтгэгдсэн үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэх	-	Үндсэн хөрөнгийг бүртгэсэн хувь	95	50	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: 1. Адаацаг суманд барьж ашиглалтад оруулсан 1,995,145,705 төгрөгийн өртөгтэй ЕБС-ын Спорт заалны барилга 2. Луус суманд барьж ашиглалтад оруулсан 895,391,326 төгрөгийн өртөгтэй ЕБС-ын 80 хүүхдийн дотуур байрны барилга 3. Дэлгэрцогт суманд барьж ашиглалтад оруулсан 2,447,379,693 төгрөгийн өртөгтэй Хүүхдийн цэцэрлэгийн барилга 4. Сайнцагаан суманд барьж ашиглалтад оруулсан 2,710,000,000 төгрөгийн өртөгтэй Хүүхдийн цэцэрлэгийн барилга 5. Сайнцагаан суманд барьж ашиглалтад оруулсан 10,147,291,762 төгрөгийн өртөгтэй Нэгдсэн эмнэлгийн барилга тус бүрийн үндсэн хөрөнгөд бүртгэх аймгийн ИТХ-ын тогтоолыг гаргуулж, хэрэгжилтийг ханган, шийдвэрийг ТӨБЗГ-т хүргүүлээ. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар:	100


						<p>1. Гурвансайхан сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 34.7 сая төгрөгийн “Халуун усны барилга”</p> <p>2. “Аймгийн төвд ангилан ялгах хогийн сав, дахивах цуглуулах сав байршуулах” 36,000,000</p> <p>3. Сургуулийн өмнөх боловсролын “Урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмж” 36,942,400</p> <p>4. Сайнцагаан сумын Мандал сургуульд “Аяга таваг ариутгалын тоног төхөөрөмж” 16,500,000 төгрөгийн өртөгтэй хөрөнгүүд тус тус бий болж, нийлүүлэгдлээ.</p> <p>Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713” төслийн хүрээнд аймгийн төв болон Эрдэнэдалай суманд цэвэрлэх байгууламж, машин механизм, багаж, тоног төхөөрөмж зэрэг нийт 12,237,128,072.02 төгрөгийн хөрөнгө бий болж, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газраас орон нутгийн өмчлөлд бүртгэх тогтоолыг баталж ирүүлээ.</p>	
1.4	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны хөрөнгийн тайланг хүлээн авах, улсын нэгтгэлд хамруулах	-	Тайлан хүлээлгэн өгөх байгууллагын тоо	142	142	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээ тайлан хүлээн авах, нэгдсэн цугларалт, сургалт зохион байгуулах тухай 2024 оны А-1/ 663 тоот албан бичгийн дагуу Орон нутгийн өмчит хуулийн	100

						<p>этгээдийн 2023 оны үндсэн хөрөнгийн тайланг нийт 142 байгууллагаас хүлээн авч, 166.7 тэрбум төгрөгийн балансийн үнэтэй барилга, байгууламж, 33,3 тэрбум төгрөгийн балансын үнэтэй машин тоног төхөөрөмж, 10.0 тэрбум төгрөгийн балансын үнэтэй тээврийн хэрэгсэл, 8.3 тэрбум төгрөгийн балансын үнэтэй тавилга, эд хогшил, 765.3 сая төгрөгийн балансын үнэтэй ном, 938,9 сая төгрөгийн балансын үнэтэй түүх соёлын дурсгалт зүйлс, 2.2 тэрбум төгрөгийн балансын үнэтэй дуусаагүй барилга, 2.6 тэрбум төгрөгийн балансын үнэтэй бусад үндсэн хөрөнгө, 561.6 сая төгрөгийн балансын үнэтэй биет бус хөрөнгийг санхүүгийн тайлан баланстай тулгалт хийж, нэгтгэн, 2024 оны 04 сарын 29-өөс 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүлээлгэн өгч, улсын тайлан мэдээнд нэгтгүүлээ.</p>	
1.5	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн харилцааг хууль, журмын дагуу аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлэх	-	Тухайн жилд гарсан тогтоолын хэрэгжилтийн хувь	100	30	<p>2024 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой нийт 18 тогтоол гарч үүнээс 3 байгууллагын 66.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий 3 тээврийн хэрэгслийг сэлбэг хэрэгслээр ашиглах, 6 байгууллагын 105 сая төгрөгийн балансын үнэ бүхий 7 байгууламжийг актлах, 1 барилга байгууламжийг дуудлагаар худалдах, нийт 5.8 сая төгрөгийн балансын үнэ</p>	100

						бүхий 35 ширхэг ашиглалтын шаардлага хангахгүй болсон машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийг акталж данснаас хасах, нийт 1 байгууллагын 172,4 сая төгрөгийн үнэ бүхий шугам сүлжээ, 53.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх, 2 байгууллагын 46.3 сая төгрөгийн балансын үнэтэй 1 тээврийн хэрэгсэл, 50 ширхэг илүүдэлтэй ашиглахгүй байгаа тоног төхөөрөмжийг дутагдалтай байгууллагад балансаас балансад шилжүүлэх, нийт 18.2 тэрбум төгрөгийн барилга байгууламжийг 6 байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх тогтоолуудыг тус тус батлуулан, тогтоолын биелэлтийг ханган ажиллаж байна.	
1.6	Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2023 оны биелэлтийг дүгнэж, 2024 оны гэрээг сунгах ажлыг зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж өгөх	-	Үндсэн арга хэмжээний биелэлтийн хувь	100	30	2024 онд Орон нутгийн өмчит 127 байгууллагатай “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”, 3 ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах “Контракт гэрээ” байгууллаа. 2023 оны гэрээний биелэлтийг дүгнэх ажил хийгдэж байна.	70
1.7	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг мэргэжил арга зүйгээр хангаж,	-	Сургалтад хамрагдсан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн	0	-	Хугацаа болоогүй	

	чадавхжуулах сургалт зохион байгуулах		гишүүдийн хувь				
1.8	Суудлын автомашины талаар гарсан журамд нийцүүлэн Орон нутгийн өмчит байгууллагуудын дотоод хэрэгцээний автомашины тоо, төрөл тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх	-	Гүйцэтгэлийн хувь	0	-	Орон нутгийн өмчит байгууллагын 57 автобус, 95 ачааны машин 6 механизм, 94 мотоцикл, 109 суудал, тусгай зориулалтын 14, цистерн 4, чиргүүл 9 данс бүртгэлд тусгагдсан. Актлах саналтай 35 тээврийн хэрэгсэл, Гаалийн бичгийн асуудалтай 5 тээврийн хэрэгсэл, засаж сэлбэж ашиглах 5 тээврийн хэрэгсэл байна. Нийт 388 тээврийн хэрэгсэлээс цэнхэр дугаартай болсон 168 тээврийн хэрэгсэл байгаа судалгааг гаргалаа.	100
							<b>85.7</b>
<b>ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ</b>							
<b>2.1</b>	<b>Зорилт 1.</b> Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 100 хувь барагдуулна.						
2.1.1	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулах	-	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь	100	-	2024 онд нийт 6 өргөдөл, гомдол ирсний дуудлагын худалдаатай холбоотой 4 иргэнээс ирсэн гомдлыг 3-г нь холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлэсэн. 1 иргэний гомдлыг “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах” журмын 4.5 дахь заалтын дагуу Орон нутгийн орлогод төвлөрүүлсэн. Орон сууц хувьчлах, гомдлыг холбогдох байгууллагад уламжлан хариу хүргүүлсэн. Үл хөдлөх хөрөнгө актлах талаар	100



						саналыг хүлээн авч албан бичгээр хариу хүргүүлэн ажиллаж байна.	
2.1.2	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланг улирал бүр аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэх	-	Хариу хүргүүлсэн тоо	4	2	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланг тухай бүрт нь ТЗУХ-т хүргүүлэн ажилласан бөгөөд 2024 оны эхний хагас жилд 2 удаа тайланг хүргэсэн байна.	100
2.1.3	Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг байгууллагын вэб хуудсаар тухай бүр мэдээллэх	-	Мэдээлэл хүргэсэн тоо	0	1	Байгууллагад өргөдөл гомдол-4, санал-1, хүсэлт-1 ирсний дагуу хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэлтийн талаарх мэдээ  мэдээллийг тухай бүр вэб хуудсанд оруулж байна.	100
2.2	<b>Зорилт 2.</b> Удирдах, удирдуулах зарчимд суурилсан иргэдэд ээлтэй, ил тод нээлттэй, авлигагүй шударга, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, хүнд суртлыг арилгах арга хэмжээ авч ажиллах	-	Ажил зохион байгуулсан байх Тийм -1 Үгүй- 0	0	1	Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой санал асуулга 1 удаа боловсруулан дуудлага худалдаанд оролцогч 5 иргэнээс авч мөн боршур боловсруулан тараасан.	100

2.2.1	Нээлттэй дуудлага худалдааны зар болон үр дүнг иргэдэд ил тод нээлттэй хүргэж ажиллах.	-	Ил тод хүргэсэн мэдээллийн байдал хувь	100	50	<p>2024 оны эхний хагас жилийн байдлаар 6 дуудлагын худалдааны зарыг Зууны мэдээ сонинд нийтлүүлсэн. Мөн байгууллагын веб хуудас болон фэйсбүүк хаягаар зарыг 100% байршуулан иргэдэд тухай бүр түгээн ажиллаж байна. Нийт 11 тээврийн хэрэгсэл, 4 үл хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдаа амжилттай зохион байгуулагдаж Орон нутгийн “Хөрөнгө худалдсаны орлого”-ын</p>  <p>дансанд 79.7 сая төгрөг, орон сууц хувьчлалын орлогоос 21.1 сая төгрөг нийт 100.8 сая төгрөгийн орлого төвлөрүүллээ.</p>	100
2.2.2	Төрийн албан хаагчидтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ тухайн албан хаагчийн иргэд үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ, чанарыг харгалзан дүгнэж, үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагчидтай хариуцлага тооцох	-	Хэрэгжилтийн хувиар	0	50	<p>Төрийн захиргааны 3, төрийн үйлчилгээний 1 нийт 4 албан хаагчийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд хүлээн авч дүгнэлээ. Эхний хагас жилийн байдлаар үүргээ хангалтгүй биелүүлж, хариуцлага тооцогдсон албан хаагч байхгүй болно</p>	100



2.2.3	Албаны болон хувийн ажлаар гадаадад явахдаа аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т мэдэгдэж, удирдамж хөтөлбөрөө батлуулан аймгийн Засаг даргаас зөвшөөрөл авах	-	Хэрэгжилтийн хувиар	0	50	2024 оны эхний хагасж илийн байдлаар албаны болон хувийн ажлаар гадаад явсан тохиолдол байхгүй болно.	100
2.2.4	Аймгийн Засаг даргаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай, чанартай зохион байгуулж ажиллах	-	Өгөгдсөн үүрэг даалгаварын хувиар	0	50	Аймгийн Засаг даргаас Дэрэн сумын нутаг дэвсгэрт байрлах “Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын даргыг томилж, ажлыг хүлээлцэх үүрэг өгөгдсөний дагуу аймгийн Засаг даргын захирамж төлөвлөн ААТҮГ-ын даргаар Дагвадоржийг томилуулж, ажил хүлээлцлээ. Гурвансайхан сумын ЗДТГ-ын орон сууцны асуудлаар газар дээр нь ажиллаж, оршин суугч иргэдтэй уулзан санал хүсэлтийг нь сонсож аймгийн Засаг даргад эргэн танилцуулсан.	100
							<b>100</b>
<b>2.3</b>	<b>Зорилт 3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, арчлах, ургуулах ажлыг зохион байгуулах.</b>						
2.3.1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 30 мод шинээр тарих	-	Тарьсан модны тоо	0	-	Аймгийн Засаг даргын 02/696 албан бичгийн дагуу “Бүх нийтээр мод тарих” 05 дугаар сарын 11-ны өдөр байгууллагын хувиарт газарт 5 ширхэг нарс модыг тарин услах ажлыг зохион байгууллаа. Мөн албан хаагчид хувьдаа мод тарих, хүлэмж байгуулж нарийн ногоо тарих ажлыг санаачлан хийлээ.	100

2.3.2	Дундговио ногооруулья хөтөлбөрийн хүрээнд хүлэмжний ногоо тариалах сургалтад байгууллагын албан хаагчдыг хамруулах	-	Сургалтад хамрагдсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	-	<p>“Дундговио ногооруулья” хөтөлбөрийн хүрээнд 04 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд сургалт зохион байгуулагдаж ахлах мэргэжилтэн</p>  <p>Н.Гэрэлмаа, мэргэжилтэн Б.Үүрийнтуяа нар хамрагдлаа</p>	100
2.3.3	Хог хаягдлаа ангилан ялгах ажилд санаачилгатай ажиллах	-	Хэрэгжилтийн хувиар	00	50	<p>Хог хаягдлаа ангилан ялгах аяны хүрээнд мэргэжилтнүүдийн өрөөнд ангилан ялгах хогийн савыг гарын доорх материалыг ашиглан бий болгон ашиглаж байна.</p> <p>Мөн “Баялаг төв” хог хаягдал авах цэгт албан хаагчид ангилан ялгасан дахивар хогийг бөөгнүүлэн 2.7кг хаягдлыг хүлээлгэн өглөө.</p> 	100
							100
2.4	<b>Зорилт 4. “Цахим байгууллага” аяны хэрэгжилтийг хангаж ажиллах</b>						

2.4.1	Байгууллагын фейсбүүк аккаунтыг шинээр нээж, хөгжүүлэх, дагагчийн тоог нэмэгдүүлэн мэдээллийг тогтмол байршуулах	-	Хандалтын тоо	0	1000	<p>2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр шинээр фэйсбүүк аккаунт хаягийг нээн хөгжүүлж дагагчийн тоог 2.9к</p>  <p>хүргээд байна.</p>	100
			Түгээсэн мэдээллийн тоо	0	-	<p>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 54, Аймгийн Засаг даргын Тамгын газрын 216, авлигатай тэмцэх газрын 19, нийт 289 мэдээ мэдээллийг өөрийн байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулан мэдээллийг түгээлээ.</p>	100
2.4.2	Байгууллагын вэбсайтад мэдээ мэдээллийг тогтмол оруулах	-	Мэдээлэл байршуулсан хувь	0	-	<p>Өмчийн харилцаатай холбоотой фото мэдээ, видео мэдээ, цаг үеийн мэдээ мэдээллийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 35 удаа тухай бүрт нь байгууллагын вэб хуудсанд байршуулан ажиллаж байна.</p> 	100

<b>2.5</b>	<b>Зорилт 5.</b> Байгууллагын мэргэшсэн албан хаагч 2020 онд 30 хувь байсныг 2024 онд 70 хувьд хүргэнэ.						
2.5.1	Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилт, үр дүнг хагас бүтэн жилээр тооцон гаргах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	50	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон сургалтын хөтөлбөрийг боловсруулж албан хаагчдаар хэлэлцүүлэн баталлаа. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийгийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 63.6%-тай, сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 62.5%-тай хэрэгжиж байна.	100
2.5.2	Нээлттэй Дундговь хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрны сул орон тоог журмын дагуу бүрдүүлж ажиллах	-	Боловсон хүчний хангалтын хувь	100	100	Аймгийн Засаг даргын 2024 оны А/355 дугаар захирамжийн дагуу байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн батлууллаа. Энэ хүрээнд дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог гаргаж төрийн албаны зохих хууль тогтоомжийн дагуу төрийн өөр байгууллага хооронд шилжин болон сэлгэн ажиллах зарыг явуулж байна. Мөн сул орон тооны захиалгыг ТАЗ-ийн Дундговь аймагт дахь салбар зөвлөлд албан бичгээр хүргүүлээ.	100
							<b>100</b>
<b>2.6</b>	<b>Зорилт 6.</b> Төрийн албаны тухай хууль Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах						
2.6.1	Төрийн албан хаагчийн хувийн хэргийг шинэчлэгдсэн журмын дагуу бүрдүүлэх	-	Албан хаагчийн тоо	6	-	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын дагуу 5 албан хаагчийн хувийн хэрэгт үзлэг хийж, шаардлагатай баримт материалыг нөхөн бүрдүүллээ. 1 сул орон тоо одоогоор нөхөгдөөгүй байгаа бөгөөд	100

						шилжин ажиллах зар зарлагдаж байна.	
2.6.2	Албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр журмын дагуу үнэлж дүгнэх	-	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн эсэх Тийм-1, Үгүй-0	1	-	Албан хаагчидтай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, эхний хагас жилийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд хүлээн авч үнэлж дүгнэлээ.	100
2.6.3	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар албан хаагчдад сургалт зохион байгуулж, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах	-	Сургалт зохион байгуулсан тоо	0	1	Хугацаа болоогүй	
							<b>100</b>
<b>2.7</b>	<b>Зорилт:7 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах</b>						
2.7.1	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталж, баримтыг байгууллагын архивт хүлээн авах	-	Хүлээн авсан баримтын тоо	30	-	2024 оны байгууллагын “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг Аймгийн Төрийн архивын баримт нягтлан шалгах арга зүйн комиссоор батлууллаа. Байнгын хадгалах баримтыг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна	100
2.7.2	Архивын баримтыг <a href="https://e-document.gov.mn/">https://e-document.gov.mn/</a> программд цахимжуулах ажлыг зохион байгуулах	-	Цахимжуулсан баримтын тоо	0	-	Архивын тасгийн даргаас заавар зөвлөмж авч, 2017-2020 оны баримтыг цахимжуулж байна. Одоогийн байдлаар <ul style="list-style-type: none"> <li>• 2016-2020 оны байгууллагын даргын тушаал</li> <li>• 2017 оны 11 тендерийн баримт бичиг</li> </ul>	100

						<ul style="list-style-type: none"> <li>Нийт 16 архивын баримтыг PDF файл болгож, <a href="https://e-document.gov.mn/">https://e-document.gov.mn/</a> программд цахимжуулан оруулаад байна.</li> </ul>	
2.7.3	Байгууллагад ирсэн, явсан бичгийг системд бүртгэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэх	-	Хариутай бичиг шийдвэрлэлтийн хувь	100	50	<p>Эхний хагас жилийн байдлаар ирсэн, явсан нийт 303 бичгийн гар бүртгэлийг хөтлөж, 113 бичгийг тухай бүр нь цахимд оруулан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Ирсэн бичиг нийт 193 байгаагаас Цаасаар ирсэн 74 бичиг</li> </ul> <p>Явсан бичиг 110 байгаагаас цаасаар гаргасан 39 бичиг байна.</p> <p>Хагас жилийн байдлаар 31 хариутай бичиг ирснийг холбогдох албан хаагчдад шилжүүлэн тухай бүр нь шийдвэрлэн ажиллаж байна.</p>	100
							<b>100</b>
<b>2.8</b>	<b>Зорилт 8. Авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах</b>						
2.8.1	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилт үр дүнг тооцох	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	-	Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны байгууллагын төлөвлөгөөнд 5 зорилт 12 арга хэмжээг төлөвлөн албан хаагчаар хэлэлцүүлэн баталлаа. 2024 оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 58.3%-тай байна.	100
2.8.2	ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлэх	-	Албан хаагчийн тоо	3	3	Авлигатай тэмцэх газар хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг өгдөг 3 албан хаагчийн ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлээ. Мөн байгууллагын удирдлага шинээр	100

						томилогдсонтой холбоотой хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг хууль журмын дагуу бөглөн хугацаанд нь тайлагналаа.	
							<b>100</b>
<b>2.9</b>	<b>Зорилт 9. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах</b>						
2.9.1	Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол улсыг болон аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, салбарын болон аймгийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын зорилт, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан бүрэн хэрэгжүүлж ажиллана.	-	Заалтын хэрэгжилтийн дундаж хувь	100	50	Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол улсыг болон аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тус байгууллагатай холбогдох заалт тусгагдаагүй. Аймгийн стратеги төлөвлөгөөнд орон нутгийн өмчийн удирдлагатай холбоотой 2 заалт тусгагдсаны дагуу хэрэгжилтийг ТЗУХ-д хугацаанд нь гаргаж тайлагнасан. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн 1 заалт хугацаа болоогүй, 1 заалт нь 100 хувь биелэсэн болно.	100
2.9.2	Үндсэн үйл ажиллагааны чиглэлд хамааралтай хууль, тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэн ажиллах	-	Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь	100	50	Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн байгууллагад хамааралтай 1 заалтын хэрэгжилтийг гарган хугацаанд нь тайлагналаа. Шийдвэрийн хэрэгжилтийн хувь 100 байна.	100
2.9.3	Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	50	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг стратеги төлөвлөгөөг холбогдох зорилтуудтай уялдуулан боловсруулж, хамт олноор хэлэлцүүлэн баталсан. Төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг хяналтад авч гүйцэтгэл 100 хувь байна.	100

2.9.4	Байгууллагын дотоод журмыг шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, батлах	-	Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлагдсан эсэх /тийм-1, үгүй -0/	1	1	2024 оны 04 дугаар сарын 10 өдөр байгууллагын алба хаагчидын хурлаар хэлэлцэж, газрын даргын А/08 тоот тушаалаар байгууллагын дотоод журмыг шинэчлэгдсэн хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн баталсан.	100
2.9.5	Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж батлуулан, үр дүнг тооцож ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	50	Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгаалалын жилийн ажлын төлөвлөгөөг аймгийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж баталсан. Төлөвлөгөөний биелэлт эхний хагас жилийн байдлаар 50 хувьтай байна.	50
2.9.6	Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах	-	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	86	50	2023 оны хяналт шинжилгээ, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний 5 заалт бүхий төлөвлөгөөг гарган баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Эхний хагас жилд төлөвлөсөн ажлын хэрэгжилт 100 хувьтай байна.	100
2.9.7	Аймгийн Засаг даргын 02 дугаар захирамжаар “Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших уриалгыг” хэрэгжүүлж соёлыг дэлгэрүүлэх	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	2	Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших уриалгын дагуу байгууллагын албан хаагчид сар бүрийн 3 дахь 7 хоногийн лхагва гаригт үндэсний дээлээ өмсөж хэвшсэн. Мөн байгууллагын албан хаагчдын хүүхдийн дунд үндэсний дээл хувцас, үндэсний тоглоом наадгайг сурталчилсан арга хэмжээг зохион байгуулж, хүүхдүүдийн дунд морь уралдуулан 4 бэрх тоглуулж тодорхой цагийг хамтдаа өнгөрүүллээ.	100
							<b>92.8</b>
<b>2.10</b>	<b>Зорилт:10</b> Байгууллагын төсвийн ил тод байдлыг хангаж төсвийн сахилга батыг сайжруулна.						



2.10.1	Батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаагаа явуулж 2023 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх	-	Аудитын зөрчилгүй дүгнэлт авсан эсэх /тийм-1, үгүй -0/	0	1	2023 оны санхүүгийн жилийн эцсийн тайланг 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөр аудитлагдаж Аудитын зөрчилгүй дүгнэлт авсан. Мөн 18/A/1270470 тоот актын төлбөр, 66/A/1270470 тоот албан шаардлагыг хүлээн авсан. 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 101 тоот албан бичгээр актын төлбөр болох 465,000 төгрөгийг барагдуулж, албан шаардлагын хариуг хүргүүлсэн болно.	100
2.10.2	Байгууллагын төсвийн мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлэх	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь	100	50	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийг тухай бүрт оруулж 159 мэдээ мэдээллэхээс хагас жилийн байдлаар 87 мэдээллийг хугацаанд нь мэдээллэсэн байна.	100
2.10.3	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль дүрэм журмын дагуу зарцуулж өр авлагагүй ажиллах	-	Өр авлагагүй ажилласан эсэх /тийм-1, үгүй-0/	1	1	2024 оны 02 дугаар сарын байдлаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, авлага үүсээгүй. Харин дотоод албан томилолт нэмэгдсэнтэй холбоотой 3.9 сая төгрөгийн өр үүссэн байна.	50
							<b>83.3</b>
<b>ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ</b>							
<b>3.0</b>	<b>Зорилт 1.</b> Төрийн албан хаагчийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлнэ.						
3.1	Салбарын шинэчлэгдэж байгаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон санхүүгийн сургалтад хамрагдах	-	Сургалтад хамрагдсан тоо	0	4	Өмчийн салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмыг байгууллагын албан ёсны цахим сайтад байршууллаа. Мөн дээрх хууль тогтоомжийн жагсаалт гарган албан хаагчдаар судлуулж байна.	100

						<p>Байгууллагын албан хаагчдын дунд Төрийн албаны тухай хуулиар сургалт зохион байгууллаа.</p> <p>Мөн өмчийн удирдлагын нэгдсэн сургалт зөвлөгөөнд 5 албан хаагч хамрагдаж 8 төрлийн сэдвээр сургалт мэдээлэл авлаа.</p> <p>Байгууллагын нягтлан бодогч Э.Саранзаяаг Өмнөговь аймагт мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагаатай танилцуулж туршлага судлууллаа.</p>	
3.2	Албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлыг турших	-	Хэрэгжилтийн тайланг БШУГ-т хүргүүлэх тоо	1	1	<p>Байгууллагын албан хаагчдын дунд Говийн ирээдүй цогцолбор сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Тогоохүүгээр “Цахим Монгол бичиг”-ийн сургалтыг 7 хоногт 2 удаа 2 цагаар зохион байгуулж байна.</p> <p>Мөн албан байгууллагад явуулах 2 удаагийн албан бичгийг хос бичгээр үйлдэн туршиж үзсэн бөгөөд хийж байгаа ажлын тайланг холбогдох гзарт нь хүргүүлж байна.</p>	100
							<b>100</b>
							<b>96.1</b>

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

/...../

(огноо)

Тэмдэг

.....

*Төлөвлөгөө тайлагнасан:*

**Төсвийн Шууд захирагч**

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

/...../

(огноо)

Тэмдэг

.....